

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Эх голомтын илч” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 116 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Архангай аймгийн Эрдэнэбулган сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, хоёрдугаар хавсралтаар баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Эх голомтын илч” ХХК (Ч.Өсөхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Тариф батлах тухай” 239 дүгээр тогтоолыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,790.0	
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	44,172.0
		Тогтмол	Төг/м ³	1,659.0

--oOo--

2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН
ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,790.0	
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	44,172.0
		Тогтмол	Төг/м ³	1,659.0
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, "00"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,400.0	
5	Орон сууцны халаалт	Хувьсах	Төг/ГЖ	22,165.0
		Тогтмол	Төг/м ³	832.0

--oOo--